



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/335

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
өвлүүлж эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайханбямбын Эрдэнэжаргалын газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөж авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өв залгамжлагч иргэн Баасангийн Хонгорзулд Хэрлэн сумын 4 дүгээр баг (Сариг), Тэмүүжингийн гудамжинд байрлах автомашины гаражийн зориулалттай 26 м<sup>2</sup> газрыг 12 жилийн хугацаатайгаар өвлүүлж эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Б.Хонгорзулын эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Б.Хонгорзулд үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/439 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ